



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн өөрийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг тус яамны Бодлого, төлөвлөлтийн газар /Г.Энхтайван/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Насантогтох/, Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК /Д.Бямбасүрэн/, эрчим хүчний барилга байгууламж барих ажлын гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, ашиглагч компанийн удирдлагуудад, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Сандуйжав/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 92, 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 198 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Ц.ДАВААСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

ТУШААЛ, ТУШААЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 125 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "...хөрөнгийн эх үүсвэр..." гэсний дараа "...өмчийн хэлбэр..." гэж нэмсүгэй.

2. Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 125 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам"-ын 3 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 3.2.1, 3.2.2 дахь заалт нэмсүгэй.

"3.2.1.15 кВ-аас доош хүчдэлийн түвшинтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын тоног төхөөрөмж, 1 Гкал/ц-аас доош хүчин чадалтай дулааны эх үүсвэр, дулаан дамжуулах төв, 200 мм-ийн голчтой болон түүнээс доош голчтой дулаан дамжуулах, түгээх шугамын угсралт, шинэчлэлт, өргөтгөлийн барилга байгууламжийг ашиглалтад оруулахад улсын комиссыг ажиллуулна."

"3.2.2.энэ журмын 3.2.1-д зааснаас бусад барилга байгууламжийг ашиглалтад оруулахад техникийн болон улсын комиссыг ажиллуулна."

3. Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 125 дугаар тушаалын 2 дахь хэсэгт "... Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ /А.Бямбадорж/..." гэснийг "...Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК /Д.Бямбасүрэн/..." гэж өөрчилсүгэй.

САЙД Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар сарын 01-ний

өдрийн 125 дугаар тушаалын хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ АЖЛЫН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгийн эх үүсвэр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр эрчим хүчний барилга байгууламж /цаашид “барилга байгууламж” гэж/ барих /барьж байгуулах, шинэчлэл хийх, сэргээн засварлах, өргөтгөх/ ажлыг зохион байгуулах хүрээнд ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулахтай холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна. /энэ заалтад ЭХС-ын 2023 оны А/36 дугаар тушаалаар орсон нэмэлтийг тусгав./

1.2. Энэхүү журмын үйлчлэлд барилга байгууламж барих ажлын захиалагч, зураг төсөл зохиогч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгч иргэн, хуулийн этгээд хамаарна.

1.3. Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэн барих ажил эхлүүлэх, тухайн барилга байгууламжийн ажлыг тодорхой нөхцөл, шалтгааны улмаас зогсоосон барилга байгууламжийн ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрлийг Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын салбарын бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж (цаашид “Эрчим хүчний яам” гэнэ) олгоно.

1.4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын салбарын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан нэгж (цаашид “Эрчим хүчний яам” гэнэ) зохион байгуулна.

1.5. Эрчим хүчний яамнаас эрх олгосон байгууллага барилгын үе шатны ажилд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлнэ.

1.6. Барилга байгууламж барих ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулахтай холбоотой мэдээллийг Эрчим хүчний яамны цахим хуудсанд нийтэд нээлттэй байршуулна.

Хоёр. Эрчим хүчний барилга байгууламж барих ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох

2.1. Барилга байгууламж барих ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоход дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

2.1.1. энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан зөвшөөрөл олгохыг хүссэн хүсэлт;

2.1.2. зураг төслийн болон барилга угсралтын ажлын гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн тухайн ажлыг эрхлэх тусгай зөвшөөрөл (лиценз)-ийн гэрчилгээний хуулбар, зохиогчийн хяналт хийлгэхээр байгуулсан гэрээ;

2.1.3. орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс газар олгосон шийдвэр, мэргэжлийн байгууллагаас авсан техникийн нөхцөл (дулаан, цахилгаан, цэвэр, бохир ус, холбоо, гал ...г.м);

2.1.4. эрх бүх байгууллагаар хянагдсан зураг төсөл;

2.1.5. барилга байгууламж барих ажилд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын ажилтны ижил төстэй ажилд 1-ээс доошгүй жил ажилласан туршлагатайг нотлох итгэмжлэл;

2.1.6. барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ, барилга угсралтын ажил хариуцсан даамал-инженерийг томилсон гүйцэтгэгчийн шийдвэр, даамал-инженерийн мэргэжлийн дипломын хуулбар, туршлагын талаарх мэдээлэл;

2.1.7. газар ашиглах, эзэмших гэрээ;

2.1.8. инженер-геологийн дүгнэлт;

2.1.9. байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт.

2.2. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн хугацаанд ажил эхлээгүй бол ажил эхлүүлэх зөвшөөрөл авах хүсэлтийг дахин шинээр гаргаж, шийдвэрлүүлнэ.

2.3. Барилга байгууламжийн үндсэн бүтээцэд болон эх үүсвэр, шугам сүлжээний хэмжээ, хүчин чадалд өөрчлөлт оруулсан бол зураг төслийг дахин боловсруулж, эрх бүхий байгууллагаар хянуулсны дараа ажил эхлүүлэх зөвшөөрөл шинээр авна.

2.4. Доор дурдсан шалтгааны улмаас тухайн барилга байгууламжид 1 сараас дээш хугацаагаар ажил зогссон тохиолдолд барилга байгууламж барих ажлыг зогсонд тооцож, ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоно:

2.4.1. захиалагч, зөвлөх үйлчилгээ эрхлэгчийн шийдвэр гарсан;

2.4.2. ажил зогсоох талаар мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гарсан;

2.4.3. ажил зогсоох талаар хууль хяналтын байгууллагын шийдвэр гарсан.

2.5. Энэ журмын 2.4-д заасан болон гэнэтийн, давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалж барилгын ажил зогссон, тухайн зөрчлийг арилгасан талаар үйл ажиллагааг нь зогсоосон байгууллагын шийдвэр, дүгнэлтийг энэ журмын 2.1-д заасан баримт бичгийн хамт захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага Эрчим хүчний яаманд гаргана.

2.6. Барилга байгууламжийн хуучирсан тоног төхөөрөмжийг өргөтгөх, шинэчлэн барихад эрх бүхий мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж энэ журмын 2.1-д заасан баримт бичгийн бүрдэлд хавсаргана.

2.7. Захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага энэ журмын 2.1-д заасан баримт бичгийг гүйцэтгэгчээр гаргуулж, ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлтийг Эрчим хүчний яаманд гаргана.

2.8. Барилга байгууламж барих ажлыг иж бүрнээр эсхүл хэсэгчлэн гүйцэтгүүлэхээр зөвшөөрөл олгож болох бөгөөд энэ тухай зөвшөөрлийн гэрчилгээнд заана.

2.9. Ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг ажлын гэрээний хугацаагаар олгоно.

2.10. Ажил зөвшөөрлийн хугацаанд дуусахааргүй тохиолдолд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага 14 хоногийн өмнө зөвшөөрөл сунгуулах тухай хүсэлтээ Эрчим хүчний яаманд гаргана.

2.11. Эрчим хүчний яам хүсэлтийг хүлээн авч ажлын гурав (3) хоногт багтаан зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлаар шийдвэр гаргана.

2.12. Зөвшөөрлийг энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан гэрчилгээгээр баталгаажуулан олгоно. Зөвшөөрлийн гэрчилгээг 2 хувь үйлдэж, 1 хувийг гүйцэтгэгчид олгоно.

2.13. Дараах үндэслэлээр барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзаж, энэ тухай албан бичгээр хариу хүргүүлнэ. Үүнд:

2.13.1. баримт бичгийг дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн;

2.13.2. баримт бичиг нь холбогдох хууль, журамд заасан шаардлага (гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч болон өргөх байгууламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын тусгай зөвшөөрлийн болон техникийн нөхцөлийн хугацаа дуусгавар болсон, байршил, газар олголт, төлөвлөлтийн болон норматив баримт бичгийн шаардлагыг зөрчсөн)-д нийцээгүй.

2.14. Захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага барилга байгууламж барих ажлын явцад барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр өөрчлөлт (гүйцэтгэгч, даамал солигдох, захиалагчийн техникийн болон зураг төсөл зохиогчийн хяналт тавих этгээд өөрчлөгдөх, гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх зөвшөөрлийн хугацаа дуусах, зураг төсөлд томоохон өөрчлөлт орох зэрэг) орсноос хойш 7 хоногийн дотор Эрчим хүчний яаманд мэдэгдэж, гэрчилгээнд холбогдох өөрчлөлтийг оруулна.

2.15. Барилга байгууламж барих ажлын зөвшөөрөл олгогдоогүй барилга байгууламжид ажил гүйцэтгэхгүй.

Гурав. Эрчим хүчний барилга байгууламж

барих ажлыг ашиглалтад оруулах

3.1. Барилга байгууламжийг барих ажлыг гүйцэтгэж дууссаны дараа ашиглалтад оруулах техникийн комисс ажиллуулах хүсэлтийг захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад, улсын комисс ажиллуулах хүсэлтийг Эрчим хүчний яаманд тус тус гаргана.

3.2. Улсын комиссын бүрэлдэхүүнийг Эрчим хүчний сайдын тушаалаар, техникийн комиссын бүрэлдэхүүнийг Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын тушаалаар энэхүү журмын гуравдугаар хавсралтын дагуу тус тус томилж, мэдэгдэл өгч ажиллуулна.

3.2.1. 15 кВ-аас доош хүчдэлийн түвшинтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын тоног төхөөрөмж, 1 Гкал/ц-аас доош хүчин чадалтай дулааны эх үүсвэр, дулаан дамжуулах төв, 200 мм-ийн голчтой болон түүнээс доош голчтой дулаан дамжуулах, түгээх шугамын угсралт, шинэчлэлт, өргөтгөлийн барилга байгууламжийг ашиглалтад оруулахад улсын комиссыг ажиллуулна.

3.2.2. Энэ журмын 3.2.1-д зааснаас бусад барилга байгууламжийг ашиглалтад оруулахад техникийн болон улсын комиссыг ажиллуулна. /3.2.1, 3.2.2 дахь заалтыг ЭХС-ын 2023 оны А/36 дугаар тушаалаар нэмсэн./

3.3. Эрчим хүчний яамны салбарын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан нэгж энэ журмын 3.10.8 дахь заалтыг нягтлан шалгасны үндсэн дээр улсын комиссыг томилно.

3.4. Улсын комиссын дарга нь ажлын зайлшгүй шаардлагаар комиссыг даргалж чадахгүйд хүрвэл өөрийгөө төлөөлөх эрхийг комиссын холбогдох гишүүнд шилжүүлж болно.

3.5. Барилга байгууламжийн зориулалт, техник технологийн онцлогтой уялдуулан холбогдох салбарын төлөөллийг улсын комиссын бүрэлдэхүүнд оруулж болно.

3.6. Улсын комиссын гишүүн өөрийгөө төлөөлөх эрхийг бусдад шилжүүлэхгүй.

3.7. Улсын комисс нь техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулах талаар дүгнэлт гаргана.

3.8. Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комиссын дүгнэлтийг үндэслэн Эрчим хүчний яамны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал эрхэлсэн нэгжээс дугаар олгосноор барилга байгууламжийг ашиглалтад орсонд тооцно.

3.9. Улсын болон техникийн комиссын хуралдааныг энэ журмын дөрөвдүгээр хавсралтаар баталсан дэгийн дагуу зохион байгуулна.

3.10. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комисс нь дор дурдсан үүрэгтэй байна:

3.10.1. ашиглалтад хүлээн авах барилга байгууламжийн техникийн баримт бичгийн иж бүрдлийг хянах, бэлтгэх, угсралтын болон ил, далд ажлын гүйцэтгэл, техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлж, улсын комисс ажиллах бэлтгэлийг хангуулах, хүсэлт гаргах;

3.10.2. барилга байгууламж, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээг барих ажил нь зураг төсөл, техникийн нөхцөлийн шаардлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл болон галын аюулгүй байдлын норм, дүрэм, хийц бүтээц, эдлэхүүн, материалын чанар стандартыг хангасан эсэхийг нарийвчлан шалгах;

3.10.3. суурилагдсан тоног төхөөрөмж, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээ, өргөх байгууламж, даралтат сав, цахилгаан шатанд сорилт туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийснийг нотлох мэргэжлийн байгууллагын дүгнэлт, итгэмжлэгдсэн лабораторийн дүн болон холбогдох бусад баримт бичгийн бэлэн байдлыг хангуулах;

3.10.4. барилга байгууламж барих ажлыг дутуу буюу чанаргүй гүйцэтгэсэн, хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын шаардлагыг зөрчсөн бол илэрсэн зөрчлийг бүрэн арилгах хүртэл техникийн комисс ажиллахгүй байх;

3.10.5. шинээр барьсан, өргөтгөсөн, шинэчлэн барьсан барилга байгууламжийг ашиглалтад оруулахад туршилт, тохируулга, зүгшрүүлэлтийн ажлыг хийсэн байх;

3.10.6. ашиглалтад оруулах барилга байгууламжид хийсэн 72 цагийн туршилтын явцад аливаа зөрчил гараагүй бол Улсын комисс ажиллах хүртэл байнгын ажиллагаанд үлдээх;

3.10.7. тухайн барилга байгууламжийн зураг төсөл, техникийн гарал үүсэл зөрөөгүй талаарх зураг төсөл зохиогчийн дүгнэлт гарсан байх;

3.10.8. илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулсны дараа энэ журмын наймдугаар хавсралтаар баталсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн бичиг баримтын иж бүрдэл, шаардлагын дагуу барилга байгууламжийг хүлээн авах.

3.11. Улсын комисс нь дор дурдсан үүрэгтэй байна:

3.11.1. барилгын ажлын гүйцэтгэлийг техникийн комиссын дүгнэлттэй уялдуулан хянаж дүгнэх;

3.11.2. барилгын ажлыг зураг төсөл, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг холбогдох баримт бичиг, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн, захиалагчийн баталгаажуулалтад үндэслэн хянаж дүгнэх;

3.11.3. хүрээлэн байгаа орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан эсэхийг дүгнэх;

3.11.4. барилга байгууламжид суурилагдсан өргөх байгууламж болон тоног төхөөрөмж, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээнд туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдлыг шалгаж, ашиглах боломжтой эсэхийг дүгнэх;

3.11.5. барилгын ажлын явцад барилгын улсын техникийн хяналт хэрэгжүүлэх байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдлыг дүгнэх;

3.11.6. Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан барилгын үйл ажиллагааны зарчим хангагдсан эсэхийг дүгнэх;

3.11.7. шаардлагатай гэж үзвэл эрчим хүчний эх үүсвэр, цахилгаан, дулааны шугам сүлжээ, дэд станцын болон тоног төхөөрөмжийн тодорхой хэсэг, далдлагдсан ажлаас сонгон авч задлан үзэж магадлан шалгах, мэргэжлийн шинжээч, итгэмжлэгдсэн лабораториор тооцоо судалгаа, сорилт шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах;

3.11.8. улсын комисс ажиллах үед техникийн комисс ажилласан барилга байгууламжийн ажил бүрэн дуусаагүй, баримт бичиг бүрдээгүй бол техникийн комиссыг дахин ажиллуулах;

3.11.9. хууль тогтоомж, норм, дүрэм, журам, стандартыг зөрчсөн гүйцэтгэгч, зураг төслийн зохиогчид хариуцлага хүлээлгэх, тусгай зөвшөөрлийг цуцлах талаарх саналыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх;

3.11.10.барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбогдсон баримт бичиг, магадлагаа, нотолгоог холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авах;

3.11.11.техникийн комисс ажиллах үед илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулсны дараа энэ журмын зургадугаар хавсралтаар баталсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлт гаргах.

Дөрөв. Эрчим хүчний барилга байгууламж

барих ажилд оролцогч талууд

4.1. Гүйцэтгэгч нь дор дурдсан үүрэгтэй байна:

4.1.1.гэрээний хугацаанд барилга байгууламж барих ажлын явцад эрх бүхий байгууллагаас захиалагчийн техникийн хяналт тавих төлөвлөгөөт хуваарийг урьдчилан тохиролцож бэлтгэл хангуулах, мөрдөх;

4.1.2.барилга байгууламжийг ашиглалтад оруулахад энэ журмын есдүгээр хавсралтаар баталсан жагсаалтын дагуу ил, далд ажлын гүйцэтгэлийн актуудыг фото болон гүйцэтгэлийн зургаар баримтжуулан бүрдүүлж, баталгаажуулан баримт бичгийн товъёог хийсэн байх, баримт бичгийн архивын иж бүрдлийг шаардлагын дагуу хангах;

4.1.3.барилга байгууламж барих ажлыг батлагдсан стандарт, технологийн дагуу гүйцэтгэж, ажлаа мэргэжлийн шинжээч, итгэмжлэгдсэн лабораторийн сорилт шинжилгээний дүн, дүгнэлтээр баталгаажуулсан байх;

4.1.4.барилга байгууламж барих ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн тохиолдолд гүйцэтгэлийн зураг боловсруулж, баталгаажуулан зураг төслийн зохиогчийн дүгнэлтийг хавсаргах;

4.1.5.барилга байгууламж барих ажлыг гүйцэтгэх явцын талбайн журналыг зохих ёсоор хөтөлж хүлээлгэн өгсөн байх;

4.1.6.суурилагдсан тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний заавар, техникийн паспорт, үйлдвэрийн туршилт зэрэг баримт бичгийн бүрдлийг хангах, тоног төхөөрөмжийн угсралтын үеийн шалгалт, ил, далд ажлын акт, тоноглолыг дангаар болон ачаалалтай явуулж туршсан протокол, хэсэгчлэн болон ажил хүлээлгэн өгсөн акт, баримт бичгийг ажлын тайланд бүрэн хавсаргах;

4.1.7.шинээр нэвтрүүлж байгаа техник, технологийн холбогдох олон улсын стандарт, барилга угсралтын ажлын технологийн карт, бусад гадаад хэл дээрх баримт бичгүүдийг монгол хэл дээр болгосон албан ёсны орчуулгын хамт хавсарган хүлээлгэж өгөх;

4.1.8.ерөнхий гүйцэтгэгч нь улсын болон техникийн комисс ажиллах үед шаардлагатай туслан гүйцэтгэгчийг байлцуулах;

4.1.9.улсын болон техникийн комиссын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж, захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаар хянуулж, баталгаажуулсан байх;

4.1.10.техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын дагуу илэрсэн зөрчлийг бүрэн арилгалгүй энэ журмын найм болон есдүгээр хавсралтаар тус тус баталсан баримт бичиг, материалыг хуурамчаар бүрдүүлж улсын комисс ажиллуулсан тохиолдолд хариуцлага хүлээх.

4.2. Захиалагч нь дор дурдсан үүрэгтэй байна:

4.2.1.барилга байгууламж барих ажлын явцад энэ журмын 4.1.1-д заасны дагуу төлөвлөгөөт хуваарийн дагуу хяналт тавих ба барилга байгууламжийн ажилд зураг төсөл, техникийн нөхцөл, стандарт зөрчвөл тухайн ажлыг зогсоох, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

4.2.2. ажил бүрэн дууссан үед техникийн комиссыг ажиллуулах;

4.2.3.энэ журмын 2.1.5-д заасан итгэмжлэл гаргахтай холбогдуулан ажилтныг мэргэшүүлэх, чадавхжуулах, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах;

4.2.4.барилга байгууламжийн ажлын зураг төсөл, тавигдах стандарт шаардлага, технологи, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл, баримт бичгийн бүрдүүлэлтийг хангуулах;

4.2.5.барилга байгууламжийн ажлын зураг төсөлд техникийн магадлал, хөндлөнгийн дүгнэлт гаргуулах;

4.2.6.техникийн комиссын хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг гаргах, эцэслэн баталгаажуулах;

4.2.7.техникийн комиссоос ажлын гүйцэтгэлийг бүрэн хүлээн авч, ажил хүлээн авах дүгнэлт баталгаажсаны дараа улсын комисс ажиллуулах хүсэлтийг Эрчим хүчний яаманд хүргүүлэх;

4.2.8.техникийн комисс ажиллах үед энэ журмын найм болон есдүгээр

хавсралтаар тус тус баталсан техникийн баримт бичиг, холбогдох материалыг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх.

4.2.9. барилга байгууламжид улсын комисс ажиллуулахтай холбогдон гарах зардлыг хариуцах.

4.3. Зураг төсөл зохиогч нь дор дурдсан үүрэгтэй байна:

4.3.1.барилгын ажлын явцад хуульд заасан чиг үүрэг, зохиогчийн хяналт хийх болон холбогдох дүрэм, журмыг баримтлан ажиллах;

4.3.2.барилга байгууламж барих ажилд зохиогчийн хяналтын гэрээг байгуулах;

4.3.3.техникийн комисс ажиллах үед зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гаргаж, биелэлтийг хангуулсан байх;

4.3.4.зураг төсөл нь холбогдох норм, журмын шаардлагыг зөрчсөн тохиолдолд энэ тухай хурлын тэмдэглэлд тэмдэглүүлж, тэдгээрийг арилгуулах арга хэмжээ авах;

4.3.5.зураг төсөл зохиогч нь улсын болон техникийн комисс ажиллах үед зураг төслийн туслан гүйцэтгэгчийн төлөөллийг байлцуулах.

4.4. Ашиглагч нь дор дурдсан үүрэгтэй байна:

4.4.1.улсын төсвийн болон гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийг барих ажлын явцад хяналт тавих гэрээг захиалагчтай байгуулах, ажлын явцын тайлан мэдээг 14 хоног тутамд захиалагчид мэдэгдэх;

4.4.2.барилга байгууламжийг барих ажлыг зураг төсөл, техникийн нөхцөлийг зөрчиж чанаргүй барих, стандартын бус тоноглол суурилуулах зэрэг зөрчил гаргавал тухайн ажлыг зогсоож, захиалагчид нэн даруй мэдэгдэх;

4.4.3.барилга байгууламж барих ажлын сорил туршилт, туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажилд оролцох, мэргэжлийн шинжээч, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн, дүгнэлттэй танилцах;

4.4.4.тухайн барилга байгууламжид хяналт тавьсан өөрийн байгууллагын инженер техникийн ажилтныг улсын болон техникийн комиссын бүрэлдэхүүнд оролцуулах, тэднийг ажиллах нөхцөл боломжоор хангах;

4.4.5.техникийн болон улсын комисс ажиллах үед барилга байгууламжийн зураг төсөл, барих ажлын гүйцэтгэлтэй танилцаж, тухайн барилга байгууламж нь цаашид хэвийн найдвартай ажиллаж, ашиглах бололцоотой эсэх талаар дүгнэлт гаргах;

4.4.6.техникийн нөхцөл, зураг төсөл зөрчсөн тохиолдолд хурлын тэмдэглэлд тэмдэглүүлж, тэдгээрийг арилгуулах санал оруулах.

4.5.Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь дор дурдсан үүрэгтэй байна:

4.5.1.барилга байгууламж барих үе шатны тодорхой ажил, үйлдвэрлэлийн технологийн сонголт, туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажил, чанар аюулгүй байдлын түвшин, төлөв байдлыг тогтоохтой холбогдсон мэргэжлийн мэргэшсэн, ур чадварын үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

4.5.2.холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд гэрээгээр хүлээсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулах, ажлын гүйцэтгэлийг хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичигт нийцүүлэн бүрэн хангах, хариуцах.

---oOo---

**Эрчим хүчний барилга байгууламж барих
ажлын журмын нэгдүгээр хавсралт
ХҮСЭЛТ**

1. Барилга байгууламжийн нэр, хүчин чадал: _____

2. Барилга байгууламж барих газар олгосон байгууллагын нэр, шийдвэрийн огноо, дугаар: _____

3. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогчийн нэр, тусгай зөвшөөрлийн огноо, дугаар, хүчинтэй хугацаа: _____

4. Зураг төсөл, техникийн баримт бичгийн иж бүрдлийн жагсаалт: _____

5. Гүйцэтгэгчийн нэр, харилцах утас, харилцах банк, дансны дугаар: _____

6. Тусгай зөвшөөрөл авсан ажлын нэр, төрөл, тоо: _____

7. Тусгай зөвшөөрлийг олгосон огноо, хүчинтэй байх хугацаа: _____

9. Эрүүл ахуй, гал, байгаль орчны зэрэг хяналтын байгууллагаас гаргасан дүгнэлтийн товч утга, техникийн нөхцөл олгосон байгууллага, тэдгээрийн шийдвэрийн огноо, дугаар: _____

11. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний огноо, дугаар: _____

12. Барилга байгууламж бариулах даамлын мэдээлэл _____

13. Зураг төсөл зохиогчийн нэр, хаяг, утасны дугаар: _____

14. Зохиогчийн хяналт хийлгэхээр байгуулсан гэрээний огноо, дугаар: _____

15. Захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хяналт хэрэгжүүлэх албан тушаалтны нэр, харилцах утасны дугаар:
(сертификатын хуулбарыг хавсаргана).

16. Захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын харилцах банк, дансны дугаар: _____

17. Иймд барилга барих ажлыг иж бүрдлээр эсхүл хэсэгчилсэн ажлуудаар "аль нь болохыг бичнэ" 20 ... оны ...-р сарын ...-ны өдрөөс 20 ... оны ...-р сарын ...-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэх зөвшөөрөл олгоно уу.

/Барилга угсралтын ажлыг хэсэгчлэн гүйцэтгэх бол ажлын төрлийг нэр зааж, тодорхой бичнэ/

18. Тус хүсэлтэд дурдсан болон түүнд орох өөрчлөлт, бусад холбогдох асуудлыг захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хяналт хэрэгжүүлэх албан тушаалтан бүрэн хариуцна. Энэ талаар гарсан ямар нэг асуудлыг тухай бүр зөвшөөрөл олгосон байгууллагад мэдэгдэж байх болно.

ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН

ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЛБАН ТУШААЛТАН:

Албан тушаал, гарын үсэг, огноо

Эрчим хүчний барилга байгууламж барих

ажлын журмын хоёрдугаар хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ,

ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

.....

/Аймаг, хотын нэр/

.....

/Зөвшөөрөл олгосон огноо/

..... /Зөвшөөрлийн дугаар/

Эрчим хүчний барилга байгууламжийн нэр, төрөл, хүчин чадал: _____

Захиалагчийн нэр: _____

Гүйцэтгэгчийн нэр, хаяг: _____

Зураг төсөл зохиогчийн нэр, хаяг, зургийн шифр: _____

Тухайн барилгын ажилд хяналт тавих захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын албан тушаалтны нэр, албан тушаал: _____

Зөвшөөрөл олгосон ажлын нэр: _____

Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа:

Зөвшөөрөл олгосон байгууллага:

Зөвшөөрөл олгосон албан тушаалтны эцгийн нэр, нэр, гарын үсэг, тэмдэг:

Эрчим хүчний барилга байгууламж барих

ажлын журмын гуравдугаар хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ

УЛСЫН БОЛОН ТЕХНИКИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. Гадаадын санхүүжилтийн эх үүсвэр, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүн:

| | |
|------------------------------|---|
| А. Улсын комиссын дарга | Эрчим хүчний яамны холбогдох газар, хэлтсийн удирдлага Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын |
| Нарийн бичгийн дарга | техникийн болон нэгжийн удирдлага |
| Гишүүд: | Эрчим хүчний яамны холбогдох газруудын төлөөлөл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл Мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөл Ашиглагч байгууллагын төлөөлөл Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төлөөлөл Зураг төслийн байгууллагын төлөөлөл Архивын байгууллагын төлөөлөл. Холбогдох салбарын төлөөлөл /зөвшилцсөнөөр/ |
| Б. Техникийн комиссын дарга* | Захиалагч / Ашиглагч/ байгууллагын техникийн болон нэгжийн удирдлага |
| Нарийн бичгийн дарга | Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллагын ажилтан |
| Гишүүд: | Ашиглагч байгууллагын төлөөлөл Харьяа салбарын төлөөлөл /зөвшилцсөнөөр/ Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл Зураг төслийн байгууллагын төлөөлөл |

Орон нутагт барьсан эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын комиссын бүрэлдэхүүнд орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийг оруулж ажиллуулна.

* Тайлбар: Хэрвээ зураг төсөл зохиогч нь ашиглагч байгууллага байх тохиолдолд тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулах Техникийн комиссын бүрэлдэхүүнийг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын холбогдох удирдлага ахлан ажиллана.

2. Эрчим хүчний тоноглол, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засварын ажлыг ашиглалтад хүлээн авах комисс дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

| | |
|----------------------|---|
| Комиссын дарга | Захиалагч байгууллагын техникийн удирдлага |
| Нарийн бичгийн дарга | Захиалагч байгууллагын техник хяналтын нэгжийн төлөөлөл |
| Гишүүд: | Захиалагч байгууллагын төлөөлөл; Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл Орон нутгийн онцгой байдлын асуудал эрхэлсэн нэгжийн төлөөлөл Орон нутаг дахь мэргэжлийн байгууллагын техникийн удирдлага Орон нутаг дахь мэргэжлийн байгууллагын холбогдох мэргэжлийн төлөөлөл Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл Зураг төслийн байгууллагын төлөөлөл Захиалагч байгууллагын санхүүгийн төлөөлөл Захиалагч байгууллагын архивын төлөөлөл |

Эрчим хүчний барилга байгууламж барих

ажлын журмын дөрөвдүгээр хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ

УЛСЫН БОЛОН ТЕХНИКИЙН КОМИССЫН ХУРАЛДААНЫ ДЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барилга байгууламжийг барих ажлын чанар, аюулгүй байдалд үнэлэлт дүгнэлт өгч, ашиглалтад хүлээн авах улсын болон техникийн комисс (цаашид комисс гэнэ)-ын хуралдааны үйл ажиллагааг энэхүү дэгээр зохицуулна.

Хоёр. Хуралд бэлтгэх

2.1. Комиссын хуралдааны бэлтгэлийг комиссын нарийн бичгийн дарга, гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулна.

2.2. Комиссын нарийн бичгийн дарга нь комиссын хуралдааныг зохион байгуулах, гишүүдэд мэдээлэл, мэдэгдэл хүргүүлэх, гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хуралдааны тэмдэглэл хөтөлж баталгаажуулах, дүгнэлт үйлдэх ажлыг гүйцэтгэнэ.

2.3. Комиссын нарийн бичгийн дарга техникийн баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан гэж үзвэл комисс ажиллах мэдэгдлийг энэ журмын 5 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу хүргүүлнэ.

Гурав. Комиссын хуралдааны үйл ажиллагаа

3.1. Комиссын гишүүдийн 75 хувь ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.2. Комисс ажиллах боломжгүй тохиолдолд гишүүдийн саналыг үндэслэн комисс дахин ажиллах тухай шийдвэрийг комиссын дарга гаргана.

3.3. Комиссын гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хурал оролцох боломжгүй тохиолдолд хурал эхлэхээс 1 хоногийн өмнө комиссын даргад урьдчилан мэдэгдэнэ.

3.4. Комиссын гишүүн нь ашиглалтад орох барилга байгууламжийн баримт бичигтэй танилцсаны дараа барилгын ажил нь зураг төсөл, холбогдох дүрэм, журам, стандарт, техникийн нөхцлийн шаардлага болон ариун цэвэр, эрүүл ахуй, галын норм, дүрэмтэй нийцсэн эсэхийг нарийвчлан шалгаж санал дүгнэлт өгнө.

3.5. Комиссын гишүүн нь өөрийн санал, дүгнэлтээ комиссын нарийн бичгийн даргад бичгээр гаргаж өгнө. Гишүүдийн бичгээр өгсөн саналыг хуралдааны тэмдэглэлд хавсаргана.

3.6. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, комиссын гишүүдийн хариуцсан асуудал тус бүрээр гаргасан саналыг үндэслэн комиссын дүгнэлтийг гаргах бөгөөд уг дүгнэлтийг комиссын нийт гишүүд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

Дөрөв. Комиссын хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх

4.1. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдааны тэмдэглэлд комиссын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

4.2. Комиссын гишүүн нь өгсөн санал дүгнэлтийнхээ биелэлтийг шалгаж, бүрэн биелсэн тохиолдолд дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулна.

---oOo---

Эрчим хүчний барилга байгууламж барих

ажлын журмын тавдугаар хавсралт

МЭДЭГДЭЛ

Дугаар ...

Комисст оролцох байгууллагын нэр

Сайдын 20... оны тоот тушаалаар баталсан Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комисс нь

барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар 20 . . . оны . . . -р сарын өдрийн цагт ажиллах болсон тул комиссын гишүүн таныг хүрэлцэн ирэхийг мэдэгдье.

Байршил: аймаг, хотын сум, дүүргийн

дугаар хороо

Комиссын нарийн бичгийн дарга /...../

20... оны...-р сарын ...-ны өдөр

Таслах

шугам

Тасалбар

Дугаар ...

Комисст оролцох байгууллагын нэр

Сайдын 20... оны тоот тушаалаар батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комисс нь

зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар 20 . . . оны . . . -р сарын өдрийн цагт ажиллах болсон тул комиссын гишүүн таныг хүрэлцэн ирэхийг мэдэгдье.

Хүлээн авсан

20... оны-р сарын-ны өдөр

Эрчим хүчний барилга байгууламж барих

ажлын журмын зургадугаар хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД

ОРУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДҮГНЭЛТ

20 ... оны ...-р сарын ...-ны өдөр Дугаар ... Улаанбаатар хот

НЭГ. Ерөнхий хэсэг

1.1. Барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал:

1.2. Хөрөнгө оруулагчийн нэр, хаяг:

1.3. Ерөнхий болон туслан гүйцэтгэгчийн нэр, хаяг:

1.4. Зураг төсөл зохиогчийн нэр, хаяг:

1.5. Эрчим хүчний сайдын 20 ... оны ...-р сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар зохион байгуулсан ... хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс нь барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай Захиалагчийн даргын 20 ... оны ...-р сарын ...-ны өдрийн ... дугаар хүсэлтийн дагуу 20 ... оны ...-р сарын ...-ны өдрөөс ... өдөрт багтаан шинээр барьсан, өргөтгөл, шинэчлэл хийсэн (доогуур нь зур) ажлын гүйцэтгэл, чанар, холбогдох баримт бичигт газар дээр нь үзлэг шалгалт хийв.

1.6. Энэхүү барилга байгууламжийг ... дугаартай зураг төслөөр 20 ... оны ...-р сараас барьж эхэлсэн ба 20 ... оны ...-р сарын ...-ны өдөр барьж дууссан байна.

ХОЁР. Дүгнэлтийн хэсэг

2.1.Энэ

байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү эрчим хүчний барилга байгууламжийн ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд хөрөнгө оруулагч, захиалагч (ашиглагч) болох

мэдэлд 20..... оны ...-р сарын ...-ны өдрөөс ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

2.2.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

2.3.Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх, баяжилт хийж байх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, засвар үйлчилгээг тогтоосон хугацаанд тогтмол хийж ажиллахыг үүгээр даалгаж байна.

2.4. Улсын комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал, барилга байгууламжийн баримт бичгийн жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Гурав. Дүгнэлтийн баталгаажуулалт

3.1.

Эрчим хүчний барилга байгууламжийг агинлалтад оруулах дүгнэлт гаргасан:

Улсын комиссын дарга: ()

Нарийн бичгийн дарга:()

Гишүүд:()

Тайлбар: Энэхүү хуудсанд Улсын комисст ажилласан гишүүдийн нэр багтаагүй тохиолдолд дараагийн хуудсанд үргэлжлүүлэн бичихдээ тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ.

---oOo---

Эрчим хүчний барилга байгууламж барих

ажлын журмын долдугаар хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ

ТЕХНИКИЙН КОМИССЫН ДҮГНЭЛТ

20..... оны...-р .. сарын...-ны өдөр Дугаар Улаанбаатар хот
НЭГ. Ерөнхий хэсэг

1.1. Барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал

1.2. Хөрөнгө оруулагч, захиалагч байгууллага

1.3. Ерөнхий ба туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага

1.4. Зураг төсөв боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага

1.5. Төрийн нарийн бичгийн даргын 20..... оны-р сарын өдрийндугаар тушаалаар зохион байгуулсан хүний бүрэлдэхүүнтэй Техникийн комисс нь уг барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай гүйцэтгэгч байгууллагын 20.....оны...-р сарын...-ны өдрийн...тоот мэдэгдлийн дагуу 20.....оны ...-р сарын ...-ны өдрөөс...өдөрт багтаан шинээр барьсан, өргөтгөл шинэчлэл, их засварын ажлын гүйцэтгэл, ажлын чанар, холбогдох акт, холбогдох бичиг баримттай газар дээр нь танилцан шалгаж үзэв.

1.6. Энэхүү барилга байгууламжийгдугаартай зураг төслөөр 20...оны сараас барьж эхэлсэн ба 20...оны ...-р сарын ...-ны өдөр барьж дууссан байна.

ХОЁР. Дүгнэлтийн хэсэг

2.1 Энэ

барилга байгууламж, түүний холбогдох акт, баримт бичгүүдийг шалгаж, ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгсний үндсэн дээр техникийн комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомж болон холбогдох дүрэм, журам, стандарт, техникийн нөхцөл, ариун цэвэр, эрүүл ахуй, галын норм дүрэмд заасан шаардлагыг хангасан тул захиалагчаас барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссыг ажиллуулах хүсэлтийг Эрчим хүчний яаманд тавих нь зүйтэй гэж дүгнэв.

2.2 . Техникийн комиссын дүгнэлтэд дараах материалыг ... хувь үйлдэж хавсаргав.

- а) барилга байгууламжийн угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл, ил, далд ажлын акт, гүйцэтгэлийн схем, зургууд, талбайн журнал . . . хуудас;
- б) техникийн зураг, техникийн баримт бичгүүд ... хуудас;
- в) техникийн бусад баримт материал ... хуудас;
- г) барилга байгууламжид ажилласан Техникийн комиссын акт . . . хуудас;
- д) техникийн комиссын гишүүдийн санал, дүгнэлт, эцсийн шийдвэрийг тэмдэглэсэн хуралдааны тэмдэглэл ... хуудас
- е) зурагт орсон өөрчлөлтийн материал ... хуудас.

ГУРАВ. Дүгнэлтийн баталгаажуулалт

3.1. Эрчим хүчний барилга байгууламжид улсын комисс ажиллуулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга:()

Нарийн бичгийн дарга:()

Гишүүд:()

Тайлбар: Энэхүү хуудсанд Техникийн комисст ажилласан гишүүдийн нэр багтаагүй тохиолдолд дараагийн хуудсанд үргэлжлүүлэн бичихдээ тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ.

---oOo---

Эрчим хүчний барилга байгууламж барих

ажлын журмын наймдугаар хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХАД

БҮРДҮҮЛЭХ ЖИШИГ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

| | Бүрдүүлж хөтөлсөн байх баримт бичиг | Баримт бичгийн огноо | Хувь |
|----|---|----------------------|------|
| | 1 | 2 | 3 |
| | 1.Зураг төсөлтэй холбоотой баримт бичиг | | |
| .1 | Зураг төсөл боловсруулах гэрээ | | |
| .2 | Зураг төсөл зохиогч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар | | |
| .3 | Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар | | |
| .4 | Зураг төсөл боловсруулах даалгавар | | |
| .5 | Техникийн нөхцөл бүрдүүлсэн тухай баримт бичгүүд (ус суваг, дулаан, цахилгаан, холбоо дохиолол) | | |
| .6 | Тухайн орон нутаг болон Нийслэлийн Засаг даргын газар олголтын захирамж | | |
| .7 | Геодезийн зураглалын ажлын тайлан | | |

| | | | |
|--|--|--|--|
| .8 | Магадлалаар баталгаажуулсан инженер геологийн судалгааны дүгнэлт | | |
| .9 | Магадлалаар баталгаажуулсан ажлын зураг төсөл, төсөв | | |
| .10 | Зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт хавсралтын хамт | | |
| .11 | Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх гэрээ | | |
| 2. Төслийн үндсэн баримт бичиг | | | |
| .1 | Төслийн үндсэн мэдээлэл | | |
| .2 | Гүйцэтгэгч байгууллагын аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар | | |
| .3 | Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар | | |
| 3. Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн баримт бичиг | | | |
| .1 | Захиалагч, ерөнхий гүйцэтгэгч байгууллагын хооронд байгуулсан хийсэн гэрээгүүд | | |
| .2 | Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжүүлэх бүртгэлийн гэрчилгээ | | |
| .3 | Барилга хариуцсан даамлыг томиолсон тушаал | | |
| .4 | Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хуваарь | | |
| .5 | Захиалагч байгууллагаар батлуулсан төсөв | | |
| .6 | Үе шатны гүйцэтгэлүүд | | |
| .7 | Барилга угсралтын ажлын явцад ирсэн, явуулсан албан бичиг | | |
| .8 | Барилга угсралтын ажлын явцад хийсэн хурлын тэмдэглэл, шийдвэрүүд | | |
| .9 | Барилга угсралтын ажлын үе шат бүрт хяналт хийсэн тайлан, фото зургууд | | |
| 4. Угсрагдсан тоног төхөөрөмжийн баримт бичиг | | | |
| .1 | Тоног төхөөрөмж үйлдвэрлэгчийн бичиг баримт, мэдээлэл | | |
| .2 | Тоног төхөөрөмжийн танилцуулга | | |
| .3 | Тоног төхөөрөмжийн гарал үүслийн тодорхойлолт | | |
| .4 | Чанарын баталгаа /үйлдвэрлэгчийн өгсөн баталгаа/ | | |
| .5 | Үйлдвэрийн лабораторийн шинжилгээ, туршилтын дүн | | |
| .6 | Ашиглалтын заавар /монгол хэлээр/ | | |
| .7 | Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийн баримт бичиг | | |
| 5. Лабораторийн дүгнэлт | | | |
| .1 | Материал, тоног төхөөрөмжийн дээжид хийсэн шинжилгээний дүгнэлт | | |
| .2 | Угсралтын ажлын явцад хийсэн туршилтын дүгнэлт | | |
| 6. Мэдээллийн сан | | | |
| .1 | Хот байгуулалтын мэдээллийн санд барилга байгууламжийг оруулсан тоон зураг хүлээн авсан акт, гүйцэтгэлийн зураг | | |
| 7. Барилгын тухай хуулийн дагуух чанарын баталгаа | | | |
| .1 | Барилгын тухай хуулийн 14.3, 14.4 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэгчийн баталгаа | | |
| 8. Техникийн комиссын баримт бичиг | | | |
| 8.1 | Техникийн комиссын тушаал | | |
| .2 | Комиссын гишүүдийн мэдэгдэл | | |
| .3 | Комиссын гишүүдийн саналын хуудас | | |
| .4 | Техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт | | |
| .5 | Хуралдааны тэмдэглэл | | |
| .6 | Техникийн комиссын дүгнэлт, акт | | |
| .7 | Захиалагч байгууллагын барилга угсралтын ажлын техникийн хяналтын талаар гаргасан нэгдсэн дүгнэлт | | |
| .8 | Зураг төслийн байгууллагаар гаргуулсан зохиогчийн нэгдсэн дүгнэлт | | |
| .9 | Ажил бүрэн дууссан, комисс ажиллуулах боломжтой тухай гүйцэтгэгч байгууллагын албан тоот, нэгдсэн тайлангийн хамт | | |
| .10 | Магадлашгүй ажлын талаарх хуралдааны тэмдэглэл, төсөв, магадлашгүй ажлын зохиогчийн дүгнэлт болон холбогдох бусад бичиг баримт | | |
| 9. Сүлжээнд залгаа цахилгаантай баримт бичиг | | | |
| .1 | Тоног төхөөрөмжид хийсэн туршилтууд | | |
| .2 | Горимын тооцоо | | |
| .3 | Сэлгэн залгалтын хөтөлбөр | | |
| .4 | Усан шахалт, угаалгын хөтөлбөр | | |
| 10. Хөрөнгийн бүртгэл | | | |
| 1.1 | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллагын холбогдох маягын дагуу барилга байгууламжийг дугсаж ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн хөрөнгийн жагсаалт | | |
| 11. Улсын комиссын баримт бичиг | | | |
| 2.1 | Улсын комиссын тушаал | | |
| 2.2 | Комиссын гишүүдийн мэдэгдэл | | |
| 2.3 | Комиссын гишүүдийн саналын хуудас | | |
| 2.4 | Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт | | |
| 2.5 | Хуралдааны тэмдэглэл | | |
| 2.6 | Улсын комиссын дүгнэлт, акт | | |
| 12. Гэрээ дүгнэж, эцсийн тооцоо хийх баримт бичиг | | | |
| 3.1 | Үе шатны ажлын сүүлийн гүйцэтгэл | | |
| 3.2 | Гэрээ дүгнэсэн тухай хуралдааны тэмдэглэл | | |
| 3.3 | Эцсийн тооцоо | | |
| 3.4 | Гэрээний хугацаа тооцох хүснэгт | | |

Жич: Тухайн төсөл арга хэмжээнд тохируулан захиалагчийн зүгээс шаардлага т ай гэж үзсэн баримт бичгийг бүрдүүлнэ.

---oOo---

Эрчим хүчний барилга байгууламж барих

ажлын журмын өсдүгээр хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ АЖЛЫН ЯВЦАД

БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

/ИЛ, ДАЛД АЖЛЫН АКТЫН ЖИШИГ МАЯГТУУД/

| № | Ил, далд ажлын актууд | Баримт бичгийн огноо | Хувь | Хавсралтын дугаар |
|---|---|----------------------|------|-------------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 |
| 1. Ерөнхий маягтууд | | | | |
| 1 | Зураг төслөөс өөрчлөгдөж хийгдсэн ажлын жагсаалт | | | M1-ЭХ |
| 2 | Гүйцэтгэлийн болон техникийн баримт бичгүүдийг хүлээлгэн өгсөн акт | | | M2-ЭХ |
| 3 | Дутуу хийгдсэн ажлын жагсаалт | | | M3-ЭХ |
| 4 | Барилга угсралтын ажлын хүрээнд угсарч суурилуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт | | | M4-ЭХ |
| 2. Цахилгаан дамжуулах, түүгээх сүлжээ, дэд станц | | | | |
| 5 | Хүчний кабель шугаманд туршилт хийсэн акт | | | M5-ЭХ |
| 6 | СИП кабель шугаманд туршилт хийсэн акт | | | M6-ЭХ |
| 7 | Хоёрдогч хэлхээний кабельд туршилт хийсэн акт | | | M7-ЭХ |
| 8 | Хүчний кабель шугамыг шулуулгасан өндөр хүчдэлээр шалгасан акт | | | M8-ЭХ |
| 9 | Кабель шугаманд муфт хийсэн акт | | | M9-ЭХ |
| 10 | Кабель шугамын шуудууг эргүүлэн булсан акт | | | M10-ЭХ |
| 11 | Кабелийг хүйтний улиралд сунгахын өмнө халаасан акт | | | M11-ЭХ |
| 12 | Кабель шугамын барилгад орох, гарах болон огтлолцолын үзлэгийн акт | | | M12-ЭХ |
| 13 | Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн үзүүлэлтийн тодорхойлолт | | | M13-ЭХ |
| 14 | Цахилгаан дамжуулах агаарын шугамын трассын дагуух газрын тодорхойлолт | | | M14-ЭХ |
| 15 | Цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр тулгуурын угсралтын ажлын акт | | | M15а-ЭХ |
| 16 | Төмөр тулгуурын тодорхойлолт | | | M15т-ЭХ |
| 17 | Төмөр тулгуурын суурийн ажлын жагсаалт | | | M15ж1-ЭХ |
| 18 | Төмөр тулгуурын суурийг угсрах ажлын журнал | | | M15ж2-ЭХ |
| 19 | Цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр бетон тулгуурыг туршсан акт | | | M16-ЭХ |

| | | | |
|-----|---|--|---------|
| 20 | Цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр бетон тулгуурын угсралтын ажлын акт | | M17а-ЭХ |
| 21 | Төмөр бетон тулгуурын тодорхойлолт | | M17т-ЭХ |
| 22 | Төмөр бетон тулгуурын угсралтын ажлын журнал | | M17ж-ЭХ |
| 23 | Цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр бетон тулгуур суурилуулалтын далд ажлын акт | | M18-ЭХ |
